



**2026 ОНЫ 2-Р САРЫН САР ХАРИУЦСАН ТАСАГ НЭГЖИЙН АЖЛЫН ТАЙЛАН**

2026.03.03

№	Үйл ажиллагааны чиглэл	Хугацаа	Хэрэгжилт	Хувь
1	Цагаан сар золголтын үйл ажиллагаа	II/23 өдөр	<p>XVII жарны Сүрээр дарагч хэмээх “Гал морь” жилийн сар шинийн баярын Нэгдсэн эмнэлгийн ажилчдын дундах нэгдсэн золголтын арга хэмжээг зохион байгуулав.</p> 	100%
2	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны сургалт	II/06 өдөр	<p>Эрүүл Мэндийн Газраас зохион байгуулсан “Хөдөлмөр, аюулгүй ажиллагаа, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа” сэдэвт Эрүүл мэндийн хөгжлийн төвийн мэргэжилтнүүдийн сургалтанд хамрагдав. Мэргэжлийнхээ хүрээнд мэдлэг, ойлголтоо баталгаажуулав.</p> 	100%
3	“Сувилахуйн хөгжил, хамтын ажиллагааны уулзалт”	II сардаа	<p>АШУУИС-ийн Дархан дахь салбар сургуулийн Сувилахуйн тэнхимтэй хамтран 11 дэх жилдээ уламжлал болгон зохион байгуулдаг “СУВИЛАХУЙН ХӨГЖИЛ–2026” бүсийн эрдэм шинжилгээний хурал амжилттай зохион байгууллаа. Хуралд Сэлэнгэ, Хөвсгөл, Орхон аймгуудаас оролцож сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр тулгамдаж буй асуудлуудыг хөндсөн, судалгаанд суурилсан илтгэлүүдийг хэлэлцүүлэв. Дархан Нэгдсэн эмнэлгээс МЭЭ тасгийн сувилагч Г.Одончимэг, Халдвартын тасгийн ахлах сувилагч Б.Бямбадорж нарын “Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн сувилагчдын темперамент болон ажлаас халшрах хам шинж хоорондын хамаарлыг судлах нь” сэдэвт илтгэл тэргүүн байр эзэлсэн бол, Амаржих тасгийн эх баригч Б.Цэндсүрэн, Н.Ёсөнбилэг, Б.Алимаа нарын “Хүүхдээ хөхөөр хооллохын ач холбогдол, хөхөө зөв амлуулах талаар жирэмсэн эхчүүдийн мэдлэг, чадварыг үнэлэх нь” сэдэвт илтгэл батламж хүртлээ.</p> 	100%

4	Шинэ сувилагчийн хөтөлбөр хэрэгжилт хангах	II сардаа	<p>2026-02-25 өдөр Сувилагч мэргэжилтний цогц чадамжийг батлах тухай” ЭМС-ын 2023 оны А/451 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах, шинэ сувилагчийг ажлын байранд сургаж дадлагажуулах зорилгоор анагаахын сургууль төгсөөд шинээр ажилд орсон “ШИНЭ СУВИЛАГЧ” сургалтыг зохион байгууллаа. Сургалтыг аймгийн ЭМГ-ын сувилахуйн мэргэжилтэн О.Хишигсүрэн, өрх, сум, хувийн хэвшлийн сувилахуйн мэргэжилтэнүүдээс бүрдсэн сургагч багш нар оролцов. Тус сургалтыг 2024 оноос эхлэн зохион байгуулж байгаа бөгөөд энэ удаагийн сургалтанд нийт 7 шинэ сувилагч нарыг хамруулан сургалтыг хийсэн.</p> 	100%
5	Төлөвлөгөөт сургалтууд	II сардаа	<p>- Сувилагч мэргэжилтнүүдийн тасралтгүй сургалтын хүрээнд эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх, бодит үзлэгийг зөв, системтэй гүйцэтгэх, практик ур чадвараар хангах, багаар ажиллах чадварыг дээшлүүлэх, дадлагажуулах зорилгоор Япон улсын Жүндэнтө их сургуулийн сувилахуйн магистрант Ш.Чанцалнямтай хамтран онол, дадлагыг хослуулсан өртөөчилсөн хэлбэрээр сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтанд нийт 23 тасгийн 92 сувилагч мэргэжилтнүүд, 13 ахлах сувилагч нар хамрагдсан. Мөн 15 тасаг нэгжид үнэлгээний аргуудаар гарын авлага бэлдэн тарааж өгсөн.</p>  <p>- 2026 оны 02 дугаар сарын 26–27-ны өдрүүдэд АШУУИС-ийн Дархан дахь салбар сургуулийн Сувилахуйн-IV, Сувилагч-III дамжааны нийт 54 оюутны төгсөлтийн өмнөх үйлдвэрлэлийн дадлагын тайлан хамгаалалтыг эмнэлзүйн орчинд, хэвтэн эмчлүүлэгчтэй тасаг нэгжүүдийн орны дэргэд зохион байгууллаа.</p>	100%
6	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын сургалт	II сардаа	<p>Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын сургалтыг “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба”-наас сувилагч, тусгай мэргэжилтэн болон жолооч нарыг хамруулсан нийт 32 хүнд онол, дадлагын сургалтыг зохион байгуулав. Энэ нь эмнэлгийн мэргэжилтэнг чадавхжуулах, эмнэлгийн тоног төхөөрөмжийг зөв горимоор аюулгүй урт хугацаанд ашиглах боломжийг олгодгоороо давуу талтай байдаг төлөвлөгөөт сургалтын нэг юм.</p>	100%

				
7	Өглөөг эрч хүчээр эхлүүлье уриатай өглөөний асуулт хариулт	II сардаа	<p>“Өглөөг эрч хүчээр эхлүүлье” уриан дор эмнэлгийн ажиллагсдын дунд өглөөний асуулт-хариултын богино арга хэмжээг зохион байгуулсан. Энэ арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлаа видео Reel болгож “Дархан Нэгдсэн эмнэлэг” дотоод фэйсбүүк группт байршуулсан. Сүрьеэ, Хоол үйлдвэрлэл шим тэжээлийн тасаг, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба нар хамтран зохион байгуулав.</p> 	100%
8	Эрүүл зөв хооллолтын сургалт	II сардаа	<p>Хугацаа хойшилсон ажил. 3-р сарын төлөвлөгөнд оруулсан.</p>	0%

Нийт 8 үйл ажиллагаа төлөвлөснөөс хэрэгжүүлж ажилласан 7 ажил, төлөвлөгөөний биелэлт 87,5%

#### Тайлан гаргасан:

- Сүрьеэгийн тасаг
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба
- Хоол үйлдвэрлэл шим тэжээлийн тасаг